46

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 05 сарын 21 өдөр Дугаар 199 Улаанбаатар хот

Шуурхай удирдлагын баг
байгуулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 13,6 дахь заалт, эрүүл мэндийн байгууллагын бэлэн, хариу арга хэмжээний шуурхай байдал, тусламж, үйлчилгээний эрсдэл, чанар, аюулгүй байдлыг хангах зорилгоор ТУШААХ нь :

1. "Шуурхай удирдлагын багийн бүрэлдэхүүн" - ийг нэгдүгээр, "Багийн ажиллах чиглэл, ажил үүргийн хуваарь" - ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Шуурхай удирдлагын багийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллаж, тайланг танилцуулж байхыг Эрүүл мэндийн дэд сайд, багийн дарга (Ж.Амарсанаа) -д даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр) үүрэг болгосугай.

САЙД Н.УДВАЛ

001360

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
05... сарын 21... өдрийн 199 тоот
тушаалын нэгдүгээр хавсралт

47

ШУУРХАЙ УДИРДЛАГЫН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Эрүүл мэндийн дэд сайд
Дэд дарга:	Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
Нарийн бичгийн дарга:	ТЗУГ – ын Шуурхай удирдлага, мэдээллийн ажилтан
Гишүүд:	БТГ –ын Салбарын аюулгүй байдал, эрсдлийн удирдлагын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
	БХЗГ-ын НЭМХ – ийн Халдварт өвчний хяналт, урьдчилан сэргийлэлтийн бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
	БХЗГ-ын НЭМХ – ийн орчны эрүүл мэндийн бодлого, хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
	БХЗГ-ын ЭТХ - ийн Яаралтай болон түргэн тусламжийн бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн
	ХШҮДАГ- ын Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн тогтолцооны бодлого, хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
	мөн газрын, яамны үйл ажиллагааны автоматжуулалт, мэдээлэл технологийн үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
	мөн газрын Цахим мэдээлэл, утасны мессэж, бусад технологиор авах гомдол саналтай холбоотой зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
	ЭМЯ-ны хэвлэл, мэдээллийн ажилтан
	НЭМГ –ын дэд дарга
	ХӨСҮТ - ийн эрсдэлийн харилцаа холбооны багийн ахлагч
	Иргэний хяналт шинжилгээний зөвлөлийн тэргүүн
	ЭМХТ-ийн Эмнэлгийн яаралтай, түргэн тусламжийн сүлжээний зохицуулалтын албаны дарга

48

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
05 сарын 21 өдрийн 199 тоот
тушаалын хоёрдугаар хавсралт

ШУУРХАЙ УДИРДЛАГЫН БАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ

Шуурхай удирдлагын багийн үйл ажиллагааны чиглэл:

- "Эрүүл мэндийн тухай", "Гамшгаас хамгаалах тухай" Монгол улсын хууль, Олон улсын эрүүл мэндийн дүрэм, шинэ болон сэргэж буй халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх стратегийн хүрээнд нийгмийн эрүүл мэндийн аливаа ноцтой байдал, халдварт өвчний дэгдэлт, цартахлын үед бэлэн байдал, хариу арга хэмжээг шуурхай удирдан зохион байгуулах;
- Эрүүл мэндийн дэд сайдын шууд удирдлага дор ажиллах бөгөөд долоо хоног бүрийн Баасан гаригт шуурхай удирдлагын даргын өрөөнд хуралдаж, тухайн 7 хоногт ирсэн мэдээллүүд авсан арга хэмжээний талаар ярилцаж, эргэх холбоогоор иргэн, төв орон нутгийн байгууллагад танилцуулах;
- Шаардлагатай онцгой тохиолдолд тухай бүр багийн хурлыг зарлан хуралдуулна.
- Салбар дундын болон салбар хоорондын мэргэжлийн байгуулагуудтай холбогдон ажиллах, үйл ажиллагааг нягт уялдуулж ажиллах;
- Төлөвлөгөө боловсруулах, үйл явдлын мэдээнд дүн шинжилгээ, хяналт, үнэлгээ хийх;
- Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын эрсдэлийн үнэлгээ хийх, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах;
- Холбогдох яам, агентлаг, төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл, мэдээллийн байгууллагатай мэдээлэл солилцох;
- Салбар дундын болон салбар хоорондын хамтын ажиллагааны уялдааг хангаж, зохицуулалт хийх, үнэлэх;
- Цар тахал болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой аливаа үйл явдлын үед хариу арга хэмжээнд оролцох холбогдох салбаруудын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааг уялдуулдан, холбогдох мэдээ, мэдээлэл, техникийн үйл ажиллагаагаар хангах;
- Хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж эргэх холбоогоор мэдээллэнэ.

Гамшиг, онцгой байдлын үед ШУБ –ын нарийн бичгийн дарга эрүүл мэндийн улсын албаны болон штабын даргад яаралтай мэдээлэх;

- Шаардлагатай тохиолдолд яамны, холбогдох мэргэжилтэнг татан оролцуулах;
- Онцгой байдлын үед нэмэлтээр төлөвлөгөө боловсруулах, шуурхай шийдвэр гаргах, хариу арга хэмжээ авах багийн үйл ажиллагаа, шаардлагатай нөөц, хангамж, санхүүжилтыг зохицуулах, шийдвэрлүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Тус баг нь яамны Шуурхай удирдлагын төв албан ёсоор үйл ажиллагаагаа явуулж эхлэх хүртэл хугацаанд ажиллана.

Багийн бүрэлдэхүүний ажил үүргийн хуваарь

ШУБ	Үндсэн ажлын чиг үүрэг	ШУБ-т хариуцах ажлын чиг үүрэг
Дарга	Эрүүл мэндийн дэд сайд	- ШУБагийг ахалж ажиллана - ШУБ ийг хуралдуулна. - Авсан арга хэмжээний тайланг тухай бүр нь Эрүүл мэндийн сайдад мэдээлэнэ - Дотоод, гадаадын байгуулалгад мэдээллийн анализ, тайлан
Дэд дарга	БХЗГ –ын дарга	- Даргыг байхгүй тохиолдолд багийг удирдаж ажиллах - Авсан арга хэмжээний тайланг тухай бүр нь ШУБ ын дарга, Эрүүл мэндийн сайдад мэдээлэнэ
Нарийн бичгийн дарга :	Шуурхай удирдлага, мэдээллийн ажилтан	- ШУБ-ийн өдөр тутмын үйл явц, арга хэмжээнд зохицуулалт хийх - Багт ирсэн ноцтой мэдээллийг зөвлөлийн дарга болон, гишүүдэд шуурхай мэдэгдэх - 323003 утсаар мэдээллийг хүлээж авах - Шуурхай хурлыг зарлах - Зөвлөлийн гишүүдээс ирэх 7-14 хоног тутмын мэдээллийг нэгтгэн, яамны удирдлагуудад мэдээллэх - Шуурхай авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах - Яамныхолбогдох мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах - Багийн даргад эргэн мэдээллэх
Гишүүд:	Салбарын аюулгүй байдал, эрсдлийн удирдлагын бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн	- Эрүүл мэндийн эрсдэлийн мэдээллийг хүлээж авч ШУБ-ын нарийн бичигт шуурхай мэдээллэх - Эрсдлэлийн үнэлгээ - Авсан арга хэмжээний тайлан гаргаж өгөх - ШУБ д мэдэгдэх
	Халдварт өвчний хяналт, урьдчилан сэргийлэлтийн бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн	- ОУЭМД-д заагдсан цагаанцэцэг, зэрлэг полиовирусээр үүсгэгдсэн халдварт полимиелит, амьсгалын замын цочмог халтай хамшинж, шинэ вирусээр үүсгэгдсэн хүний

		томуугийн сэжигтэй тохиолдлын мэдээллийн хүлээж авах - 1 цагийн дотор шуурхай удирдлагын багт мэдээлнэ - Хариу арга хэмжээг ХӨСҮТ, мэргэжлийн багуудтай хамтран зохион байгуулна - Авсан арга хэмжээний тайлан гаргаж өгөх - Эргэн мэдээллэх
	Яаралтай болон түргэн тусламжийн бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн	- Нийтиг хамарсан гамшиг, онцгой байдал болсон тохиолдолд ШУЗ-ын нарийн бичигт шуурхай мэдээллэх - холбогдох тушаал, шийдвэрийн дагуу ГХЭМУАлба, штабад мэдээлэл дамжуулж, үйл ажиллагааг нь идэвхжүүлэх - ЭМХТ, мэргэжлийн агийдыг мэргэжил аргазүйгээр удирдаж ажиллах - Эрүүл мэндийн кластерийн үйл ажиллагаанд оролцох - Авсан арга хэмжээний тайлан ШУБ ын даргад гаргаж өгөх - Эргэн мэдээллэх
	Цахим мэдээлэл, утасны мессэж, бусад технологиор авах гомдол саналтай холбоотой зохицуулалт	- Засгийн газрын “1111” төвд ирсэн мэдээллийг нэгтгэх, хариу арга хэмжээ авсан байдлын талаар ШУЗ-ын нарийн бичигт 7-14 хоногт мэдээллэх. - Ноцтой мэдээллийг цаг алдалгүй ШУБ-д болон нарийн бичигт мэдээллэх
	Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны автоматжуулалт, мэдээлэл технологийн үйлчилгээ	- Сүлжээний хэвийн байдлыг хангах - Яаралтай болон гамшиг ослын үед ЭМХТ-д мэдээллэх - Теле хурлын үед яамны талаас техникийн бэлэн байдлыг хангах
	Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн тогтолцооны бодлого, хэрэгжилтийн зохицуулалт	- Халдвар өвчин болон, нийтийг хамарсан хордлого, халдварын үеийн мэдээллийг ШУБ болон ҮАБЗөвлөлд мэдээллэх
	Хэвлэлийн төлөөлөгч	- ШУЗ-ийн хийж хэрэгжүүлсэн болон ноцтой асуудалд яаралтай арга хэмжээ авсан талаарх мэдээг 7-14 хоног тутамд яамын сайтад байршуулах - Нийтийг хамарсан байгалийн гамшиг, осол гэмтэл, хордлого, халдварт өвчин, эмч: эмнэлгийн ажилчдын алдаа эндэгдлийн талаарх мэдээллийн дагуу олон нийтийн хэрэгслийн зохицуулалт хийх, холбох

	ХӨСҮТ - ийн эрсдэлийн харилцаа холбооны багийн ахлагч	- Эрсдэлийн харилцаа холбооны багт ирсэн мэдээллийг ШУ ын мэдээллийн ажилтанд мэдэгдэх - батлагдсан журмын дагуу хариу арга хэмжээг зохион байгуулах -
	ЭМХТ- ийн Эмнэлгийн яаралтай, түргэн тусламжийн сүлжээний зохицуулалтын албаны дарга	- Гамшиг, онцгой байдлын үед ажиллах мэргэжлийн ангиудыг бэлэн байлгах - Мэргэжил аргазүйгээр удирдах - Мэргэжлийн ангудын нөөцийн судалгааг гаргах тэдгээрийн дайчлах - Бэлэн байдлын сургалт - Эрсдэлийн үнэлгээ - Эмнэлгийн яаралтай тусламжийн зохицуулалт хийх, хариу арга хэмжээ авах - Шаардлагатай тохиолдолд нүүдлийн эмнэлгийг ажиллуулах
	Эрүүл мэндийн Иргэний хяналт шинжилгээний зөвлөлийн тэргүүн	- Хөндлөнгийн хяналт - Тусгай балтагдсан маягтын дагуу ирэгдийн гомдол, саналыг хүлээж авах, нэтгэж боловсруулах - ШУБ- ын мэдээллийн ажилтанд мэдэгдэх - Хариу арга хэмжээг эргэх холбоогоор мэдэгдэх